

ЭНТРЕПРЕНЕРИЙН БОЛОВСРОЛ БОЛОН ОЮУТАН СУРАЛЦАГЧДЫН ЭНТРЕПРЕНЕР БОЛОХ ЗОРИЛГЫН ХООРОНДЫН ХАМААРАЛ: ЭНТРЕПРЕНЕР СЭТГЭЛГЭЭНИЙ ЗУУЧЛАХ НӨЛӨӨ

З.Алтанчимэг*, Ц.Цэцэгмаа**

Хураангуй: Энэхүү судалгаагаар энтрепренерийн боловсрол, оюутан суралцагчдын энтрепренер болох зорилгын хоорондын хамааралд энтрепренер сэтгэлгээний зуучлах нөлөөг судлахыг зорьсон. Судалгааг Монгол Улсын гурван их, дээд сургуулийн бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж буй оюутнуудаас санамсаргүй түүврээр сонгон асуулгын аргаар мэдээлэл цуглуулан, хэмжил зүйн хувьсагчдын найдварт байдал болон хамаарлын шинжилгээ хийн, бүтцийн тэгшитгэлийн загварчлал (SEM) ашиглан үр дүнг гаргасан. Энэхүү судалгаанд үл хамаарах хувьсагчаар энтрепренерийн боловсрол, хамаарах хувьсагчаар энтрепренер болох зорилго, зуучлагч хувьсагчаар энтрепренер сэтгэлгээг авч үзсэн. Энтрепренерийн боловсрол нь оюутан суралцагчдын энтрепренер болох зорилго болон энтрепренер сэтгэлгээнд эерэг нөлөө, энтрепренер сэтгэлгээ нь оюутан суралцагчдын энтрепренер болох зорилгод эерэг хүчтэй нөлөө үзүүлдэг болохыг судалгааны үр дүн харуулж байна. Мөн энтрепренерийн боловсролоор дамжуулан оюутан суралцагчдад энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлэх нь энтрепренер болох зорилгыг өдөөдөг болох нь энэхүү судалгааны үр дүнгээс харагдлаа. Их дээд сургуулиуд үр дүнтэй энтрепренерийн сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь оюутан суралцагчдын энтрепренер сэтгэлгээг хөгжүүлж энтрепренер болох зорилгыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг болох нь бидний судалгааны үр дүн харуулж байна.

Түлхүүр үгс: Энтрепренерийн боловсрол, энтрепренер сэтгэлгээ, энтрепренер болох зорилго, бакалаврын оюутнууд

THE RELATIONSHIP BETWEEN ENTREPRENEURSHIP EDUCATION AND STUDENTS' ENTREPRENEURIAL INTENTION: THE MEDIATING EFFECT OF AN ENTREPRENEURIAL MINDSET

Abstract: The purpose of this study was to explore the potential mediating role of entrepreneurial mindset in the association between entrepreneurial education and students' entrepreneurial intention. The study was conducted among a randomly selected sample of 368 business administration students from three universities in Mongolia. To test the advanced hypotheses, the study employed factor appropriateness and reliability analysis, correlation analysis, and structural equation modeling (SEM). The SEM model examined the relationship between entrepreneurial education (independent variable) and entrepreneurial intention (dependent variable) while considering the entrepreneurial mindset as a mediator. The study findings indicate a positive and significant average effect of entrepreneurial education on both students' intention to become an entrepreneur and their entrepreneurial mindset. Also, the results show the positive and significant effect of an entrepreneurial mindset on entrepreneurial intention. These results suggest that cultivating an entrepreneurial mindset through entrepreneurial education can stimulate the goal of becoming an entrepreneur among students. Our research indicates that entrepreneurship education programs offered by universities play a vital role in cultivating the entrepreneurial mindset of students, enabling them to become successful entrepreneurs.

Keywords: Entrepreneurship education, entrepreneurial mindset, entrepreneurial intention, undergraduate students

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): altanchimegz@num.edu.mn;

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): tsetsegmaats@num.edu.mn;

Удиртгал

Энтрепренершип нь эдийн засгийн өсөлт, хөгжлийг өдөөх чадамжтай учраас сүүлийн жилүүдэд судлаачид ихээхэн анхаарал хандуулах болсон. Бизнес нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, инновацыг зах зээлд нэвтрүүлж, шинэ ажлын байр бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой байлгахад чухал үүрэгтэй (Shane & Venkataraman, 2000) учраас хөгжингүй болон буурай хөгжилтэй орнуудад аль алинд нь чухал асуудал болж байна (Vdlander & et al, 2020). Судлаачид бизнес эрхлэлтийг улс орны хөгжлийн зайлшгүй чухал хэсэг бөгөөд эдийн засгийн зохистой өсөлтийг бий болгодог хөгжлийн хөдөлгөгч хүчний нэг гэж үздэг (Baumol & et al, 2007). Бизнес эрхлэгчид инновацыг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж (Licbn & et al, 2011; Ribeiro-Soriano, 2017), улмаар улс орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжил, өсөлтөд чухал хувь нэмэр оруулдаг гэдгийг өмнөх судалгаануудад дурдсан байдаг (Li & et al, 2020; Neneh, 2020).

Монгол улсад сүүлийн жилүүдэд шинэ технологи, инновац дээр суурилсан шинэ санаа хөгжүүлэгч старт-ап компаниуд бий болж, хөгжиж эхэлсэн хэдий ч их сургуулийн төгсөгчдийн ажил эрхлэлт, залуусын ажилгүйдэл нь нийгмийн тулгамдаж буй чухал асуудлуудын нэг хэвээр байна. Иймд их, дээд сургууль, коллежууд энтрепренер сэтгэлгээтэй төгсөгчдийг бэлтгэх, оюутан суралцагчдын бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор энтрепренерийн боловсрол олгох ажлыг эхлүүлж, бизнес эрхлэх үр чадварыг төлөвшүүлэх нь дээд боловсролын гол асуудлын нэг гэж үзэж байна. Инновац, бүтээлч сэтгэлгээг өндөр үнэлдэг өнөө үед бизнес эрхлэх нь хувь хүмүүсийн, ялангуяа бакалаврын түвшний оюутнуудын дунд улам бүр түгээмэл болж байна. Бизнес эрхлэгчийн хувьд амжилтанд хүрэхийн тулд зөвхөн тодорхой үр чадварыг эзэмших төдийгүй энтрепренер сэтгэлгээтэй байх нь чухал. Оюутан суралцагчдад шаардлагатай мэдлэг, үр чадвар эзэмшүүлэх зорилготой энтрепренерийн боловсрол нь бизнес эрхлэхийг дэмжих чухал бүрэлдэхүүн хэсэг гэдгийг судлаачид хүлээн зөвшөөрөх болсон. Иймд энэхүү судалгаа нь бакалаврын оюутнуудын энтрепренер болох зорилго болон энтрепренерийн боловсролын хоорондын хамаарал, эдгээр хүчин зүйлсийн хамааралд энтрепренер сэтгэлгээний зуучлах нөлөөг судлах зорилготой юм.

Онолын судалгаа

Энтрепренерийн боловсрол (Entrepreneurship Education)

Энтрепренерийн боловсрол нь амжилттай бизнес эрхлэхэд шаардлагатай үр чадваруудыг төлөвшүүлэх, энтрепренер болгох зорилгыг нэмэгдүүлэх, дэмжих

үнэ цэнтэй арга юм (Anwar & et al, 2022; Bae & et al, 2014; Bischoff & et al, 2019). Энтрепренерийн боловсрол нь оюутнуудын бизнес эрхлэх хандлага, ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, үйл явцыг хамардаг (Cui & et al, 2021; Fayolle & et al, 2006; Yuan & et al, 2020). Өөрөөр хэлбэл, энтрепренерийн боловсрол нь оюутнуудад бизнес эрхлэгч болоход шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн цогц сургалтын үйл явц юм (Hussain & Norashidah, 2015; Licbn & et al, 2008). Үүнд бизнес эрхлэх онол, практикийн аль алиныг нь хамарсан хичээлүүд, мөн бизнес эрхлэх ур чадварыг хөгжүүлдэг тухайлбал туршлага судлах, зөвлөх хөтөлбөр зэрэг арга зүйн бусад хэлбэрүүд, багтаж болно. Энтрепренерийн боловсролоор дамжуулан оюутан суралцагчид бизнесийн салбарт амжилтад хүрэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлага, хувийн шинж чанаруудыг олж авдаг бөгөөд энэ нь тэдний хувийн болон мэргэжлийн амьдралд эерэг өөрчлөлтийг бий болгодог (Ginanjar, 2016). Энтрепренерийн боловсрол нь оюутнуудын бизнес эрхлэх хүсэл эрмэлзлийг төлөвшүүлэхэд зайлшгүй шаардлагатай энтрепренершипийн агуулга, бизнес эрхлэх туршлага зэрэг янз бүрийн элементүүдийг багтаасан цогц бөгөөд олон талт бүтэц юм (Zhao & et al, 2005). Тиймээс оюутнуудын энтрепренер зорилгыг өдөөхийн тулд багш профессорууд эдгээр элементүүдийг агуулсан олон төрлийн сургалтын боломжоор хангах шаардлагатай (Bagheri & et al, 2013). Энтрепренерийн боловсрол нь оюутнуудын хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэх ур чадварт хувь нэмэр оруулж, эдсийн дүндээ эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулдаг (Wu, et al., 2022). Мөн оюутнуудын бизнесийн мэдлэг, ур чадварт эергээр нөлөөлж, бизнес эрхлэх хандлагыг нэмэгдүүлж, сургуулиа төгссөний дараа жижиг бизнест оролцох оролцоог нэмэгдүүлдгийг өмнөх судалгаанууд харуулж байна (Egan & et al, 2017; Keat & et al, 2011; Vaughan, 2014).

Энтрепренер болох зорилго (Entrepreneurial Intention)

Энтрепренер болох зорилго нь хувь хүний бизнес эхлүүлэх шийдвэрийг тодорхойлдог чухал хүчин зүйл бөгөөд бизнес эрхлэх судалгаа, практикт ихээхэн анхаарал хандуулсан чухал ойлголт юм. Энтрепренер болох зорилго гэдэг нь янз бүрийн дотоод болон гадаад хүчин зүйлсийн нөлөөнд автдаг цогц бүтэц юм. Дотоод хүчин зүйлд хувь хүний зан чанар, сэдэл, үнэт зүйлс багтдаг бол гадаад хүчин зүйлд нийгмийн хэм хэмжээ, соёлын үнэт зүйлс, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг багтдаг (Kueger & Carsrud, 1993). Судлаач Ajzen (1991)-ийн үзэж байгаагаар энтрепренер болох зорилго оюутнуудын хүсэл эрмэлзэл, үйлдэл хийх хандлага, хэрэгжүүлэх боломжтой эсэх зан үйлийн хүчин зүйлүүдээр илэрдэг. Энтрепренер болох зорилго нь бизнес

эрхлэхийг эрмэлздэг хүмүүсийн танин мэдэхүйн төлөв байдал (Krueger & et al, 2000). Энэ нь тэдний дотоод хүсэл эрмэлзэл, урам зориг, арга хэмжээ авч, бизнес эрхлэхэд бэлэн байгааг харуулдаг. Өөрөөр хэлбэл, шинэ бизнес эхлүүлнэ гэсэн хувь хүний итгэл үнэмшил, түүнийг ирээдүйд хэзээ нэгэн цагт хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлнэ (Thompson, 2009). Энтрепренер болох зорилго нь шинэ бизнес эхлүүлэхээр төлөвлөж буй хүмүүсийн шийдвэр гаргах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг (Nabi & et al, 2010). Энэ нь хувь хүмүүсийг бизнесийн шинэ санаа бий болгож, бизнес эрхлэх, бизнесийн талбарт карьераа эхлүүлэхэд түлхэц өгдөг сэтгэлгээ (Chhabra & et al, 2020) бөгөөд тухайн хүний шинэ бизнес эхлүүлэх өөрийн чадвартаа итгэх итгэлээр тодорхойлогддог (Hsu, et al., 2018). Сүүлийн үед судлаачдын дунд оюутнуудын энтрепренер болох зорилгыг судлах сонирхол улам нэмэгдэж байна (Вае & et al, 2019). Оюутнуудын энтрепренер болох зорилгод нөлөөлж буй хүчин зүйлсийг ойлгох нь оюутнуудын дунд бизнес эрхлэхийг дэмжих, урамшуулах үр дүнтэй энтрепренерийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ гэж үздэг.

Энтрепренер сэтгэлгээ (Entrepreneurial Mindset)

Бизнес эрхлэх нь зөвхөн карьер сонголт биш, харин хувь хүмүүст амжилтад хүргэх сэтгэлгээ юм. Бидний амьдарч буй хурдацтай, байнга өөрчлөгдөж буй ертөнцөд энтрепренер сэтгэгчдийн хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Энтрепренер сэтгэлгээ гэдэг нь бизнес эрхлэх боломжуудыг олж илрүүлэх, эрэлхийлэхэд зайлшгүй шаардлагатай зан байдал, зан үйл, ур чадварын цогцыг хэлдэг. Үүнд инновац, бүтээлч байдал, эрсдэл хүлээх, санаачилгатай байх зэрэгт чиглэсэн сэтгэлгээний арга барил, түүнчлэн өөрчлөлт, тодорхойгүй байдлыг хүлээн зөвшөөрөх хүсэл орно. Энтрепренер сэтгэлгээтэй хүмүүс ихэвчлэн бие даасан байдаг бөгөөд тэд асуудал шийдвэрлэх ур чадвартай, шинэ нөхцөл байдалд суралцах, дасан зохицох хүсэл эрмэлзэлтэй байдаг. Энтрепренер сэтгэлгээ нь бүтээлч, шинэлэг сэтгэлгээнд хандах мэдрэмж, хандлагаар тодорхойлогддог (Gynzel-Jensen & et al, 2017) бөгөөд хувь хүний хандлага, бизнес эрхлэх үйл ажиллагаатай нягт холбоотой байдаг. Энтрепренер сэтгэлгээ нь шинэ боломжуудыг нээж, хүсэл тэмүүллийг нэмэгдүүлээд зогсохгүй инновацыг бий болгож, энгийн сэтгэлгээг шинэлэг систем болгон хувиргадаг. Энтрепренер сэтгэлгээг бий болгосноор хувь хүмүүс бүтээлч, шүүмжлэлтэй, харилцаа холбоо, хамтын сэтгэлгээгээр дамжуулан асуудлыг тодорхойлж, шийдлийг боловсруулж, харилцаа холбоог бий болгох чадвартай болдог. Энтрепренер сэтгэлгээ нь энгийн хүмүүст ер бусын амжилтад хүрэх боломжийг олгодог. Судлаач Khandayati болон бусад эрмэмтэд (2020)

энтрепренерийн боловсрол нь хувь хүний энтрепренер сэтгэлгээг хоёр талаас нь хөгжүүлдэг хэмээн үзсэн. Нэгдүгээрт, энтрепренерийн боловсрол нь хувь хүмүүст бизнес эрхлэх гүн гүнзгий ойлголт, бизнес эрхлэх соёлын талаарх мэдлэгтэй болоход тусалдаг. Хоёрдугаарт, энтрепренерийн боловсрол шинэ бизнесийг үр дүнтэй эхлүүлэх, удирдахад практик туршлага хуримтлуулахын ач холбогдлын талаарх хүмүүсийн ойлголтыг нэмэгдүүлдэг.

Энтрепренерийн боловсрол болон энтрепренер болох зорилгын хоорондын хамаарал

Сүүлийн жилүүдэд судлаачид энтрепренерийн боловсрол, энтрепренер болох зорилгын хоорондын хамааралд ихээхэн анхаарал хандуулах болсон. Энтрепренерийн боловсрол нь хувь хүмүүст энтрепренер болох зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх замаар бизнес эрхлэх тухай мэдлэг, хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх боломжтой (Kalyoncuoğlu & et al, 2017). Түүнчлэн, бизнес эрхлэх сургалт, хөтөлбөрт хамрагдах нь оюутнуудын бизнес эрхлэх хүсэл эрмэлзэлд эергээр нөлөөлдөг болохыг олон судалгаа харуулж байна (Souitaris & et al, 2007). Энтрепренерийн боловсрол нь оюутны бизнес эрхлэх хандлага, хүсэл эрмэлзлийг төлөвшүүлэхээс гадна шинэ бизнесийг бий болгоход тусалдаг (Licbn, 2008). Мөн оюутнуудын бизнес эрхлэх хүсэл эрмэлзэл, ойлголтыг өөрчилдөг болохыг эрдэмтэн Gerba (2012) өөрийн судалгаагаар баталсан. Тэрээр энтрепренерийн боловсрол эзэмшсэн оюутнуудын энтрепренер болох зорилго нь боловсрол эзэмшээгүй оюутнуудтай харьцуулахад илүү өндөр байдаг хэмээсэн. Энтрепренерийн боловсрол нь оюутнуудын энтрепренер болох зорилго хооронд хүчтэй хамаарал байгааг олон судалгаа харуулж байна (Fayolle & Gailly, 2015; Hou & et al, 2019; Lindberg & et al, 2017; Mei & et al, 2020; Wei & et al, 2019). Өмнөх судалгаануудын үр дүнд үндэслэн энтрепренерийн боловсролд хамрагдаж буй оюутнууд бизнес эрхлэх чиглэлээр карьераа өсгөх магадлал өндөр байдаг гэж үзэж болно. Тиймээс дараах судалгааны таамаглалыг дэвшүүлж байна.

H1: Энтрепренерийн боловсрол нь энтрепренер зорилгод эерэг нөлөө үзүүлднэ.

Энтрепренерийн боловсрол болон энтрепренер сэтгэлгээний хоорондын хамаарал

Өнгөрсөн хугацаанд хийсэн судалгаанууд нь энтрепренерийн боловсрол болон сэтгэлгээний хөгжил хоёрын хооронд эерэг хамааралтай болохыг харуулсан (Karyaningsih & et al, 2020; Pfeifer & et al, 2016; Rodriguez & Lieber, 2020;

Wardana, et al., 2020). Энтрепренерийн боловсрол нь энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг (Handayati, et al., 2021; Pfeifer, Sarlija & et al, 2016; Saptono & et al, 2020; Rodriguez & Lieber, 2020). Бүтээлч байдал, шинийг санаачлах, эрсдэл хүлээх, боломжийг танин мэдэх зэрэг бизнес эрхлэх гол чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн боловсрол, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан энтрепренер сэтгэлгээг хөгжүүлж болно. Эдгээр хөтөлбөрүүд нь хувь хүмүүст энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлж, янз бүрийн нөхцөлд амжилтад хүрэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэгийг хөгжүүлэхэд тусалдаг (Dewi & et al, 2019). Их дээд сургуулийн түвшинд энтрепренерийн боловсрол нь оюутнуудад бизнесийн туршлага хуримтлуулах, практик сургалт явуулах боломжийг олгодог сургалтын арга барилыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Ийм арга барил нь оюутнуудад энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлж, бизнес эхлүүлэх, эрхлэхэд тулгарч буй практик сорилтод бэлтгэхэд тусална (Cui & et al, 2021; Ndou & et al, 2019). Судлаач Wu болон Wu (2008) энтрепренерийн боловсрол нь бизнес эрхлэх онол болон практик сургалтаар дамжуулан оюутнуудын бизнес эрхлэх мэдлэг, сэтгэлгээ, хүсэл эрмэлзэл, чадварыг дээшлүүлэхэд чиглэгддэг гэж онцолсон. Энтрепренерийн боловсролд дизайн сэтгэлгээ, хандлагыг оруулах нь энтрепренер сэтгэлгээг нэмэгдүүлэх боломжтой юм (Daniel, 2016). Өөрөөр хэлбэл, боломжийг ухамсарлах, эрсдэлийг хүлээн зөвшөөрөх, тодорхой бус байдлыг тэсвэрлэх, өөдрөг үзэл зэргээр илэрдэг бизнес эрхлэх сэтгэлгээ нь энтрепренерийн боловсролоор төлөвшинө (Cui & et al, 2021). Эдгээр судалгааны үр дүнд үндэслэн бид дараах таамаглалыг боловсруулсан.

H2: Энтрепренерийн боловсрол нь энтрепренер сэтгэлгээнд эерэг нөлөө үзүүлдэг.

Энтрепренер сэтгэлгээ болон энтрепренер болох зорилгын хоорондын хамаарал


Энтрепренер сэтгэлгээтэй хүмүүс хувийн бизнесээ эхлүүлэх, бизнес эрхлэх боломжийг эрэлхийлэх сонирхолтой байдаг нь судалгаагаар тогтоогджээ (Abdelwahed & Alshaikhmubarak, 2023; Cui & et al, 2021; Handayati, et al., 2021; Licbn & Fayolle, 2015). Бүтээлч, шинийг санаачлагч, эрсдэлд орох хандлагатай хүмүүсийн бизнес эрхлэх хүсэл эрмэлзэл өндөр байдаг нь энтрепренер сэтгэлгээ болон энтрепренер болох зорилгын хооронд эерэг хамаарал байгааг харуулж байна (Fini & et al, 2012; Obschonka & et al, 2019). Шинийг санаачлагч, бие даасан, идэвхтэй байх зэрэг бизнес эрхлэх шинж чанаруудыг төлөвшүүлэх нь энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэхэд эергээр нөлөөлж, бизнес эрхлэх үйл ажиллагаанд илүү их оролцоход хүргэдэг (Jung & Lee, 2020). Судлаач Licbn, Fayolle (2015) нарын судалгаагаар энтрепренер

сэтгэлгээтэй оюутнууд бизнес эрхлэхэд илүү эерэг хандлагатай, бизнес эхлүүлэх чадвартаа илүү итгэлтэй, эрсдэл хүлээх хүсэл эрмэлзэлтэй болохыг харуулсан. Энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлэх нь их сургуулийн оюутнуудын энтрепренер болох зорилгыг нэмэгдүүлдэг (Mukhtar & et al, 2021). Өмнөх судалгаанууд нь энтрепренер сэтгэлгээтэй хүмүүс бусад хүмүүсээс илүү бизнес эрхлэх үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцдог гэж үзэхэд хүргэж байна. Эдгээр үр дүнд үндэслэн дараагийн таамаглалыг дэвшүүлж байна.

H3: Энтрепренер сэтгэлгээ нь энтрепренер болох зорилгод эерэг нөлөө үзцүлнэ.

H4: Энтрепренер сэтгэлгээ нь энтрепренерийн боловсрол энтрепренер болох зорилгын хоорондын хамааралд зуучлах үүрэг гүйцэтгэнэ.

Судлагдсан байдлыг судалгааны үр дүнд үндэслэн бид энтрепренер сэтгэлгээ нь энтрепренерийн боловсрол, энтрепренер болох зорилгын хооронд зуучлах үүрэг гүйцэтгэдэг гэсэн загварыг санал болгож байна. Энэ хамаарлыг харуулахын тулд судалгааны дараах загварыг боловсруулсан бөгөөд Зураг 1-д харууллаа.



Судалгааны арга зүй

Мэдээлэл цуглуулах ба түүврийн хэмжээ

Энэхүү судалгааны мэдээллийг МУИС, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж буй оюутнуудаас мэдээлэл цуглуулсан. Санал асуулгыг онлайнгаар 2023 оны 2-р сарын 27-ноос 2023 оны 3-р сарын 31-ний хооронд явуулсан. Microsoft Forms онлайн санал асуулгын платформоор дамжуулан нийт 368 асуулга цуглуулсан.

Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээллийг Хүснэгт 1-д үзүүлэв. Судалгаанд оролцогчдын 45.9% нь МУИС-ийн оюутан, 26.4% нь ХААИС-

ийн оюутан, 27.7% нь Хүмүүнлэгийн их сургуулийн оюутан байсан. Судалгаанд оролцогчдын 23.9% нь менежментийн чиглэлээр, 23.4% нь маркетингийн чиглэлээр суралцагч байсан. Хүний нөөцийн менежмент энэ чиглэлээр суралцаж буй оюутнуудын хамгийн бага буюу 2.4 хувийг эзэлж байна. Судалгаанд эмэгтэй суралцагчид идэвхтэй оролцсон бөгөөд оролцогчдын 70.1% нь эмэгтэй, 29.6% нь эрэгтэй оюутнууд байсан. Суралцсан жилээр нь авч үзвэл 28.3% нь 1-р түвшний суралцагч, 16.3% 2-р түвшний суралцагч, 23.9% 3-р курс түвшний суралцагч, 26.4% 4-р түвшний суралцагч, үлдсэн 5.2% нь 5-р түвшний суралцагч оюутнууд байна.

Хүснэгт 1. Судалгааны оролцогчдын ерөнхий мэдээлэл

	Үзүүлэлт	N	%
Нас	18-20	165	44.8
	21-23	177	48.1
	24-26	26	7.1
	Нийт	368	100.0
Хүйс	Эмэгтэй	258	70.1
	Эрэгтэй	109	29.6
	Нийт	368	100.0
Сургууль	МУИС	169	45.9
	ХААИС	97	26.4
	ХИС	102	27.7
	Нийт	368	100.0
Суралцаж буй түвшин	1-р түвшин	104	28.3
	2-р түвшин	60	16.3
	3-р түвшин	88	23.9
	4-р түвшин	97	26.4
	5-р түвшин	19	5.2
	Нийт	368	100.0
Мэргэжл	Аялал жуучлал	17	4.6
	Банк	44	12
	Даатгал	20	5.4
	Кибернетик	19	5.2
	Маркетинг	86	23.4
	Менежмент	88	23.9
	Нягтлан бодох бүртгэл	20	5.4
	Санхүү	18	4.9
	Хүний нөөцийн менежмент	9	2.4
	Худалдаа	28	7.6
	Эдийн засаг	19	5.2
	Нийт	368	100.0

Судалгааны асуулга ба найдвартай байдал

Судалгааны асуулга нь хоёр хэсгээс бүрдсэн. Эхний хэсэгт оролцогчдын талаарх үндсэн мэдээллийг багтаасан бол хоёр дахь хэсэгт энтрепренерийн боловсрол, энтрепренер сэтгэлгээ, энтрепренер болох зорилготой холбоотой хувьсагчдыг хэмжсэн. Энэхүү судалгаа нь өмнөх судлаачдын туршиж, баталгаажуулсан хэмжүүрүүдийг ашигласан бөгөөд Likert-ын 1-ээс 5 онооны шатлалаар оюутнуудын хариултыг үнэлсэн.

Энтрепренерийн боловсрол: Энтрепренерийн боловсролыг хэмжихийн тулд Handayani & et al's (2021) боловсруулсан зургаан асуулгыг ашигласан. Энтрепренершип боловсролын хэмжүүрийн Cronbach-ийн альфа нь 0.915, КМО утга нь 0.935, Bartlett's Test Sphericity тестийн ач холбогдол нь 0.000 $0 < 0.05$ байна.

Энтрепренер болох зорилго: Оюутнуудын энтрепренер болох зорилгыг үнэлэхийн тулд Lisbn болон бусад эрдэмтдийн (2011) судалгааны зургаан асуулгыг ашигласан. Энтрепренер болох зорилгын Cronbach-ийн альфа нь 0.877, КМО утга нь 0.890, Bartlett's Test Sphericity тестийн ач холбогдол нь 0.000 $0 < 0.05$ байна.

Энтрепренер сэтгэлгээ: Энтрепренер сэтгэлгээг үнэлэхийн тулд Wardana болон бусад эрдэмтдийн (2020) судалгаандаа ашигласан зургаан асуулгыг ашигласан. Энтрепренер сэтгэлгээний хэмжүүрийн Cronbach-ийн альфа нь 0.894, КМО утга нь 0.878, Bartlett's Test Sphericity тестийн ач холбогдол нь 0.000 $0 < 0.05$ байна.

Бүх хэмжүүрийн найдвартай байдал өндөр бөгөөд найдвартай байдлын коэффициент нь 0.7-оос их, КМО-ийн утга 0.5-аас их, Bartlett's Test Sphericity тестийн ач холбогдол нь 0.000 $0 < 0.05$ байна.

Загварын үнэлгээ, хэмжилт

судалгааны үр дүнг шинжлэхдээ SPSS 23.0, Smart PLS 4.0 зэрэг статистик мэдээллийн шинжилгээний хэрэгслийг ашигласан. Хэмжил зүйн хувьсагчдын найдварт байдлыг шалгаж, хувьсагч тус бүрийн тодорхойлох статистикийг тооцоолон, хамаарлын шинжилгээ хийн, бүтцийн тэгшитгэлийн загварчлал (SEM) ашиглан үр дүнг гаргасан.

Судалгааны үр дүн

Хэмжил зүйн хувьсагчдын найдварт байдлын шинжилгээ

Хэмжил зүйн хувьсагчдын хоорондын хамаарлын коэффициентыг

тодорхойлохын тулд хүчин зүйлийн ачааллын шинжилгээ хийж (factor loading), Cronbach-ийн альфа, нийлмэл найдвартай байдал (CR) болон дундаж вариацийг (AVE) тооцсон. Шинжилгээний үр дүнг (Хүснэгт 2)-д харуулаа.

Хүснэгт 2. Хэмжил зүйн хувьсагчдын найдварт байдлын шинжилгээ

		Энтрепрениршип боловсрол	Энтрепренер болох зорилго	Энтрепренер сэтгэлгээ	Cronbach Alpha	CR	AVE
Энтрепренер боловсрол (Entrepreneurial Education-EE)	EE1	.790			.915	.924	.671
	EE2	.777					
	EE3	.838					
	EE4	.787					
	EE5	.812					
	EE6	.784					
Энтрепренер болох зорилго (Entrepreneurial Intention-EI)	EI1		.730		.877	.905	.615
	EI2		.770				
	EI3		.876				
	EI4		.850				
	EI5		.867				
	EI5		.811				
Энтрепренер сэтгэлгээ (Entrepreneurial Mindset-EM)	EM1			.818	.894	.919	.651
	EM2			.786			
	EM3			.810			
	EM4			.729			
	EM5			.770			
	EM6			.729			

Note: CR, a square of the summation of the factor loadings; AVE, a summation of the square of the factor loadings; α , Cronbach's alpha.

Шинжилгээний үр дүнгээс харахад хүчин зүйлсийг хэмжих асуултуудын нийцтэй байдлын утгууд 0.729-0.867 хооронд хэлбэлзэж байна. Хүчин зүйлүүдийн дотоод нийцлийг үнэлэхийн тулд бид Cronbach-ийн альфа тооцсон бөгөөд энэ нь 0.877-0.932 хооронд хэлбэлзэж байсан нь бүх хүчин зүйлийн (>0.70) хангалттай найдвартай байдлыг харуулж байна (Nunnally, 1978). Хувьсагчдын нийлмэл найдвартай байдлын (CR) утга нь 0.905-аас 0.943-ын хооронд байсан нь санал болгож буй хамгийн бага утга болох 0.70-аас дээш байсан (Hair & et al, 2019) нь хүчин зүйлсийн найдвартай байдал

өндөр байгааг харуулж байна. Дундаж дисперсийн утгыг (AVE) тооцоолсон бөгөөд бүх AVE бүтцийн утгууд нь 0.615-аас 0.804 хооронд хэлбэлзэж байна. Нуугдмал хувьсагч бүрд AVE коэффициент нь далд утгатай хувьсагчийн хоорондох бусад корреляцийн утгуудаас бүгд 0.50-аас дээш (Hair & et al, 2019) учир гарсан учир практик ач холбогдолтой, ялгах чадвартайг харуулж байна.

Хүчин зүйлсийн хоорондын хамаарлын шинжилгээ

Хувьсагчдын тодорхойлох статистик болон хүчин зүйлсийн хоорондын хамаарлыг тогтоохын тулд корреляцийн шинжилгээ хийсэн бөгөөд үр дүнг (Хүснэгт 3)-т харуулав.

Хүснэгт 3. Хүчин зүйлсийн хоорондын хамаарлын шинжилгээний үр дүн

	Mean	SD	EE	EI	EM
Entrepreneurial Education-EE	3.3804	.87850	1		
Entrepreneurial Intention-EI	3.2355	.82815	0.428	1	
Entrepreneurial Mindset-EM	3.4801	.92656	0.627	0.735	1

***Significant at the 0.001 level; **significant at the 0.01 level; * significant at the 0.05 level.

Шинжилгээгээр судалгаанд оролцогчдын хувьд энтрепренерийн боловсрол нь энтрепренер болох зорилго [$r = .428, p < 0.01$], энтрепренер сэтгэлгээнд [$r = .627, p < 0.01$] эерэг дундаж хамааралтай байна. Харин энтрепренер сэтгэлгээ нь энтрепренер болох зорилго [$r = .735, p < 0.01$] эерэг мэдрэгдэхүйц хамааралтай болох нь харагдлаа.

Бүтцийн тэгшитгэлийн загварчлал (SEM)


Бүтцийн загвар ба хувьсагчдын ач холбогдлыг шалгахын тулд PLS шинжилгээнд зориулж R-Square-ийг тооцоолсон. Шинжилгээний явцад бие даасан болон хамааралтай хувьсагчдын хоорондын хамаарлыг хянаж үзсэн. Шинжилгээний үр дүн нь бүх таамаглалыг дэмжиж, регрессийн жингийн утгууд эерэг, ач холбогдолтой гарсан ($p < 0.01$). Судалгааны үр дүнг 4-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4. Судалгааны үр дүн PLS-SEM

Hypothesis	Path	Standardize Beta	Standard Error	T statistics	P value	Remarks
H1	EE→EI	0.371***	0.035	11.209	.000	Supported
H2	EE→EM	0.411***	0.062	9.752	.000	Supported
H3	EM→EI	0.716***	0.075	14.627	.000	Supported

Note: ***: $p < 0.001$; **: $p < 0.01$; *: $p < 0.05$, significance levels are two-tailed

Хэмжилтийн загварын үнэн зөв, найдвартай байдлыг тогтоосны дараа дараагийн алхам нь PLS алгоритм болон Bootstrapping алгоритмыг ажиллуулах замаар таамагласан хамаарлыг шалгасан.



Зураг 2, Хүснэгт 4-т дурдсанчлан судалгааны бүх таамаглалууд судалгааны үр дүнгээр батлагдсан. Судалгааны үр дүнгээс харахад энтрепренерийн боловсрол нь энтрепренер болох зорилготой ($\beta = 0.371$) эерэг хамааралтай бөгөөд дундаж нөлөө үзүүлдэг ($t = 11.209$; $p < 0.001$), энтрепренер сэтгэлгээтэй эерэг хамааралтай ($\beta = 0.411$) бөгөөд дундаж нөлөө үзүүлдэг ($t = 9.752$; $p < 0.001$) болох нь харагдлаа. Энтрепренер сэтгэлгээ нь нь энтрепренер болох зорилготой ($\beta = 0.716$) эерэг хамааралтай бөгөөд хүчтэй нөлөө үзүүлдэг ($t = 14.627$; $p < 0.001$) байна.

Энтрепренерийн боловсрол болон энтрепренер болох зорилго хоорондын хамааралд энтрепренер сэтгэлгээ зуучлах нөлөө үзүүлж буй эсэхийг шалгахын тулд Smart PLS-д нэгтгэсэн аргыг ашигласан. Хүснэгт 5-д үзүүлсэн үр дүнгээс харахад энтрепренер сэтгэлгээ нь энэхүү харилцаанд бүрэн зуучлагч болох нь тогтоогдсон бөгөөд энэ нь Variance Accounted for Variance Accounted

(VAF)-д тооцсоноор энтрепренер зорилгын үр нөлөөний 18.2%-ийг харуулж байна. Энэхүү үр дүн нь энтрепренерийн боловсролоор дамжуулан оюутан суралцагчдын энтрепренер болох зорилгыг нэмэгдүүлэхэд тулд энтрепренер сэтгэлгээний зуучлалын үүрэг гүйцэтгэдэг болохыг баталгаажуулсан. Тиймээс H4-г дэмжигдсэн.

Хүснэгт 5. Энтрепренер сэтгэлгээний зуучлах нөлөө

Hypothesis	Path	Path Coefficient		Indirect Effect	Standard Error	T statistics	P value	Remarks
		c	c'	a*b				
H4	EE→EM→EI	.335***	.517***	.182***	.045	11.455	.000	Supported

***: $p < 0.001$; **: $p < 0.01$; *: $p < 0.05$

Холбогдох зохицуулагч хувьсагчдын (Бета коэффициент) бүх нөлөө эерэг ба статистикийн хувьд чухал ($p < 0.01$) учраас таамаглалууд бүгд батлагдсан.

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгааны гол зорилго нь бизнесийн удирдлагын чиглэлээр их дээд сургуульд суралцаж буй оюутнуудын энтрепренерийн боловсрол, энтрепренер сэтгэлгээ, энтрепренер болох зорилгын хоорондын уялдаа холбоо болон энтрепренер сэтгэлгээний зуучлах нөлөөг судлах явдал байсан. Судалгааны үр дүн бүх таамаглалыг батлагдсан.

- Оюутны энтрепренерийн боловсрол, энтрепренер болох зорилго хоёрын хооронд эерэг, дундаж хамаарал байгааг харуулсан бөгөөд илүү их энтрепренер боловсрол эзэмшсэн оюутнууд бизнес эрхлэх хандлага илүү байгааг харуулж байна. Эдгээр үр дүн нь Fayolle болон Gailly (2015), Lindberg болон бусад эрдэмтэд (2017), Hou болон бусад эрдэмтэд (2019), Wei болон бусад эрдэмтэд (2019), болон Mei болон бусад эрдэмтэд (2020) зэрэг өмнөх олон судлаачдын судалгааны үр дүнтэй нийцэж байна. Судалгааны үр дүн энтрепренерийн боловсрол нь оюутан суралцагчдад энтрепренер болох зорилго бий болоход чухал нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна.
- Судалгааны хоёр дахь гол үр дүн нь оюутны энтрепренерийн боловсрол болон энтрепренер сэтгэлгээ хоёрын хооронд эерэг, дундаж хамааралтай болохыг харуулж байна. Энтрепренерийн боловсрол нь мэдлэг, хандлага, ур чадвар олгохоос гадна бизнес эрхлэх сэтгэлгээг төлөвшүүлэх, сэдлийг нэмэгдүүлэхэд тусалдаг. Судалгааны үр дүн нь Pfeifer ба бусад эрдэмтэд (2016), Karyaningsih болон бусад эрдэмтэд

(2020), Rodriguez ба Lieber (2020), Saptono болон бусад эрдэмтэд (2020), Wardana болон бусад эрдэмтэд (2020), Handayati болон бусад эрдэмтдийн (2021) судалгааны үр дүнтэй нийцэж байна. Энэ нь энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлэх, бэхжүүлэхэд энтрепренер боловсролын үүрэг чухал болохыг онцолж байна. Боломжийг эрэлхийх, эрсдэлийг хүлээн зөвшөөрөх, тодорхой бус байдлыг үнэлэх, тухайн нөхцөлд оновчтой шийдвэр гаргах зэрэг мэдлэг, ур чадварыг олгох замаар энтрепренерийн боловсрол нь энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэх хүчирхэг хэрэгсэл болж чадна.

- Судалгааны гурав дахь гол үр дүн нь оюутны энтрепренер сэтгэлгээ, энтрепренер болох зорилго хоёрын хооронд эерэг мэдэгдэхүйц хамааралтай болохыг харуулж байна. Эдгээр үр дүн нь Fini ба бусад эрдэмтэд (2012), Lisbn болон Fayolle (2015), Obschonka болон бусад эрдэмтэд (2019), Handayati болон бусад эрдэмтэд (2021), Cui болон бусад эрдэмтэд (2021), Mukhtar болон бусад эрдэмтэд (2021), Abdelwahed болон Alshaikhmubarak (2023) зэрэг олон судлаачдын судалгааны үр дүнтэй нийцэж байна. Энтрепренер сэтгэлгээ нь хувь хүмүүст бизнес эрхлэх боломжийг эрэлхийлж, таатай үр дүнд хүрэх хурдасгуур болж чадна. Өөрөөр хэлбэл, энтрепренер сэтгэлгээтэй хүмүүс саад бэрхшээл, бүтэлгүйтлийн оронд боломжийг олж хардаг тул энтрепренер болох зорилго өндөр байх хандлагатай байдаг болохыг судалгааны үр дүн харуулж байна.
- Эцэст нь, судалгаагаар энтрепренерийн боловсрол, энтрепренер болох зорилгын хоорондын хамааралд энтрепренер сэтгэлгээ нөлөөлдөг эсэхийг үнэлэхийг зорьсон. Судалгааны үр дүнгээс харахад энтрепренер сэтгэлгээ нь энтрепренерийн боловсрол, энтрепренер болох зорилгын хоёрын хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, энтрепренерийн боловсрол нь оюутан суралцагчдад энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлж, тэдний энтрепренер болох зорилгыг шууд бусаар нэмэгдүүлэх боломжтой болохыг харуулж байна. Энэ нь оюутнуудын бизнес эрхлэх хүсэл эрмэлзлийг дэмжихэд чиглэсэн сургалт, хөтөлбөрүүдийн үр нөлөө нь энтрепренер сэтгэлгээг хэр төлөвшүүлж байгаагаас хамаарна гэсэн үг юм.

Дүгнэлт

Энэхүү судалгаа нь их дээд сургуулийн оюутнуудын дунд энтрепренерийн боловсрол болон энтрепренер болох зорилгын хоорондын уялдаа холбоо, энэхүү

харилцан хамааралд энтрепренер сэтгэлгээ хэрхэн нөлөөлдөг болохыг судлахад чиглэсэн. Үр дүн нь энтрепренерийн боловсрол, энтрепренер болох зорилгын хооронд эерэг хамаарал байгааг харуулсан бөгөөд энтрепренер сэтгэлгээ нь энэхүү харилцааг дэмжих нөлөө үзүүлж байгаа нь харагдлаа. Судалгааны үр дүн нь оюутнуудын энтрепренер болох зорилго тавих, энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэхэд энтрепренерийн боловсрол чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг онцолж байна. Нэмж дурдахад энэхүү судалгаа нь энтрепренерийн боловсрол нь бизнес эрхлэх зорилгод нөлөөлөхөд энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлэхийн ач холбогдлыг онцолсон өмнөх судалгаануудтай нэгдмэл байр суурьтай байна. Их дээд сургуулиуд оюутан суралцагчдын энтрепренер сэтгэлгээг төлөвшүүлэх, тэдний бизнес эрхлэх хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн энтрепренерийн олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлэх, арга хэмжээ зохион байгуулах, энтрепренер соёлыг төлөвшүүлэх нь чухал болохыг судалгааны үр дүн харуулж байна.

Хязгаарлалт ба ирээдүйн хандлага

Энэхүү судалгаа нь зарим нэг талаараа хязгаарлагдмал байгааг дурдах нь зүйтэй. Нэгдүгээрт, судалгааны түүврийн хэмжээг Монголын гурван их, дээд сургуулийн бизнесийн удирдлагын чиглэлээр суралцдаг 368 оюутнуудаар хязгаарласан. Хоёрдугаарт, судалгаа нь асуулга цуглуулах үйл явцын хувьд хязгаарлагдмал байсан бөгөөд зөвхөн онлайн асуулгаар тодорхой хугацаанд өгөгдлийг цуглуулсан.

Ашигласан материал

- Abdelwahed, N. A., & Alshaikhmubarak, A. (2023). Developing Female Sustainable Entrepreneurial Intentions through an Entrepreneurial Mindset and Motives. *Sustainability*, 15(7), 6210. doi:10.3390/su15076210
- Ajzen, I. (1991). The theory of planned behavior. *Organizational Behavior and Human Decision Processes*, 50(2), 179-211. doi:10.1016/0749-5978(91)90020-T
- Anwar, I., Thoudam, P., Samroodh, M., Thoudam, M., & Saleem, I. (2022). The dataset on fear of failure, entrepreneurship education, and psychological and contextual predictors of entrepreneurial intention. *Frontiers in Psychology*, 13, 954285. doi:10.3389/fpsyg.2022.954285
- Bae, T. J., Qian, S., Miao, C., & Fiet, J. O. (2014). The Relationship Between Entrepreneurship Education and Entrepreneurial Intentions: A

- Meta-Analytic Review. *Entrepreneurship: Theory and Practice*, 38(2), 217-254. doi:10.1111/etap.12095
- Bagheri, A., Lope-Pihie, Z. A., & Krauss, S. E. (2013). Entrepreneurial leadership competencies among Malaysian university student entrepreneurial leaders. *Asia Pacific Journal of Education*, 33(4), 493-508. doi:10.1080/02188791.2013.822789
- Baumol, W. J., Litan, R. E., & Schramm, C. J. (2007). *Good Capitalism, Bad Capitalism, and the Economics of Growth and Prosperity*. New Haven & London: Yale University Press. doi:10.2139/ssrn.985843
- Bischoff, L. L., Otto, A.-K., Hold, C., & Wollesen, B. (2019). The effect of physical activity interventions on occupational stress for health personnel: A systematic review. *International journal of nursing studies*, 97, 94-104. doi:10.1016/j.ijnurstu.2019.06.002
- Chhabra, S., Raghunathan, R., & Rao, N. M. (2020). The antecedents of entrepreneurial intention among women entrepreneurs in India. *Asia Pacific Journal of Innovation and Entrepreneurship*, 14(1), 76-92. doi:10.1108/APJIE-06-2019-0034
- Cui, J., Sun, J., & Bell, R. (2021). The impact of entrepreneurship education on the entrepreneurial mindset of college students in China: The mediating role of inspiration and the role of educational attributes. *The International Journal of Management Education*, 19(1), 100296. doi:10.1016/j.ijme.2019.04.001
- Daniel, E. (2016). The Usefulness of Qualitative and Quantitative Approaches and Methods in Researching Problem-Solving Ability in Science Education Curriculum. *Journal of Education and Practice*, 7(15), 91-100.
- Dewi, D. P., Nurfajar, A. A., & Dardiri, A. (2019). Creating Entrepreneurship Mindset Based on Culture and Creative Industry in Challenges of The 21st Century Vocational Education. *Proceedings of the 2nd International Conference on Vocational Education and Training (ICOVET 2018)*. *Advances in Social Science, Education, and Humanities Research*, 242, pp. 67-70. Atlantis Press. doi:10.2991/icovet-18.2019.18
- Egan, A., Maguire, R., Christophers, L., & Rooney, B. (2017). Developing creativity in higher education for 21st-century learners: A protocol for a scoping review. *International Journal of Educational Research*, 82, 21-27. doi:10.1016/j.ijer.2016.12.004
- Fayolle, A., & Gailly, B. (2015). The Impact of Entrepreneurship Education

- on Entrepreneurial Attitudes and Intention: Hysteresis and Persistence. *Journal of Small Business Management*, 53(1), 75-93. doi:10.1111/jsbm.12065
- Fayolle, A., Gailly, B., & Lassas-Clerc, N. (2006). Effect and Counter-effect of Entrepreneurship Education and Social Context on Student's Intentions. *Estudios De Economia Aplicada*, 24(2), 509–523.
- Fini, R., Grimaldi, R., Marzocchi, G. L., & Sobrero, M. (2012). The Determinants of Corporate Entrepreneurial Intention Within Small and Newly Established Firms. *Entrepreneurship: Theory and Practice*, 36(2), 387-414. doi:10.1111/j.1540-6520.2010.00411.x
- Gerba, D. T. (2012). Impact of Entrepreneurship Education on Entrepreneurial Intentions of Business and Engineering Students in Ethiopia. *African Journal of Economic and Management Studies*, 3(2), 258-277. doi:10.1108/20400701211265036
- Ginanjari, A. (2016). Entrepreneurship Education and Entrepreneurial Intention on Entrepreneurship Behavior: a Case Study. *Proceedings of the 2016 Global Conference on Business, Management, and Entrepreneurship* (pp. 683-686). Bandung, Indonesia: Atlantis Press. doi:10.2991/gcbme-16.2016.129
- Günzel-Jensen, F., Moberg, K., Mauer, R., & Neergaard, H. (2017). Self-Efficacy and the Entrepreneurial Mindset Revisited. In M. Brännback, & A. Carsrud, *Revisiting the Entrepreneurial Mind* (Vol. International Studies in Entrepreneurship, pp. 319-335). Springer. doi:10.1007/978-3-319-45544-0_20
- Hair, J. F., Risher, J. J., Sarstedt, M., & Ringle, C. M. (2019). When to Use and How to Report the Results of PLS-SEM. *European Business Review*, 31(1), 2-24. doi:https://doi.org/10.1108/EBR-11-2018-0203
- Handayati, P., Wibowo, A., Narmaditya, B. S., Kusumojanto, D. D., Setiawan, A. B., & Tung, T. D. (2021). The university students enterprises development: Lesson from Indonesia. *Cogent Education*, 8(1), 1973286. doi:10.1080/2331186X.2021.1973286
- Hou, F., Su, Y., Lu, M., & Qi, M. (2019). Model of the Entrepreneurial Intention of University Students in the Pearl River Delta of China. *Frontiers in Psychology*, 10, 916. doi:10.3389/fpsyg.2019.00916
- Hsu, D. K., Burmeister-Lamp, K., Simmons, S. A., Foo, M.-D., Hong, M., & Pipes, J. D. (2018). 'I know I can, but I don't fit': Perceived

- fit, self-efficacy, and entrepreneurial Intention. *Journal of Business Venturing*, 34(2), 1-4. doi:10.1016/j.jbusvent.2018.08.004
- Hussain, A., & Norashidah, D. (2015). Impact of Entrepreneurial Education on Entrepreneurial Intentions of Pakistani Students. *Journal of Entrepreneurship and Business Innovation*, 2(1), 43-53. doi:10.5296/jebi.v2i1.7534
- Jung, E., & Lee, Y. (2020). College Students' Entrepreneurial Mindset: Educational Experiences Override Gender and Major. *Sustainability*, 12(19), 8272. doi:10.3390/su12198272
- Kalyoncuoğlu, S., Aydın, B., & Güksel, A. (2017). The Effect of Entrepreneurship Education on Entrepreneurial Intention: An Experimental Study on Undergraduate Business Students. *Journal of Management Research*, 9(3), 72-91. doi:10.5296/jmr.v9i3.11282
- Karyaningsih, P. D., Wibowo, A., Saptono, A., & Narmaditya, B. S. (2020). Does entrepreneurial knowledge influence vocational students' intentions? Lessons from Indonesia. *Entrepreneurial Business and Economics Review*, 8(4), 138-155. doi:10.15678/EBER.2020.080408
- Keat, O. Y., Selvarajah, C., & Meyer, D. (2011). Inclination towards entrepreneurship among university students: An empirical study of Malaysian university students. *International Journal of Business and Social Science*, 2(4), 206-220.
- Krueger, N. F., & Carsrud, A. (1993). Entrepreneurial intentions: Applying the theory of planned behavior. *Entrepreneurship and Regional Development*, 5(4), 315-330. doi:10.1080/08985629300000020
- Krueger, N. F., Reilly, M. D., & Carsrud, A. (2000). Competing Models of Entrepreneurial Intention. *Journal of Business Venturing*, 15(5-6), 411-432. doi:10.1016/S0883-9026(98)00033-0
- Li, C., Murad, M., Ashraf, S. F., Syed, N., & Riaz, M. (2020). Entrepreneurial nascent behavior: The role of causation process in opportunity discovery and creation. *Entrepreneurial Business and Economics Review*, 8(4), 183-200. doi:10.15678/EBER.2020.080410
- Licón, F. (2008). Skill and value perceptions: How do they affect entrepreneurial intentions? *International Entrepreneurship and Management Journal*, 4(3), 257-272. doi:10.1007/s11365-008-0093-0
- Licón, F., & Fayolle, A. (2015). A systematic literature review on entrepreneurial intentions: Citation, thematic analyses, and research

- agenda. *International Entrepreneurship and Management Journal*, 11, 907-933. doi:10.1007/s11365-015-0356-5
- Licón, F., Moriano, J. A., & Zarnowska, A. (2008). Stimulating entrepreneurial intentions through education. In J. A. Leyn, M. Gorgievski, & M. Lukes, *Teaching Psychology of Entrepreneurship: Perspective from Six European Countries* (pp. 45-67). Madrid: Universidad nacional de Educacion a Distancia.
- Licón, F., Rodríguez-Cohard, J. C., & Rueda-Cantuche, J. M. (2011). Factors Affecting Entrepreneurial Intention Levels: A Role for Education. *International Entrepreneurship and Management Journal*, 7(2), 195-218. doi:10.1007/s11365-010-0154-z
- Lindberg, E., Bohman, H., Hultén, P., & Wilson, T. L. (2017). Enhancing students' entrepreneurial mindset: A Swedish Experience. *European Journal of Training and Development*, 41(5), 450-466. doi:10.1108/EJTD-10-2016-0078
- Mei, H., Lee, C.-H., & Xiang, Y. (2020). Entrepreneurship Education and Students' Entrepreneurial Intention in Higher Education. *Education Sciences*, 10(9), 257. doi:10.3390/educsci10090257
- Mukhtar, S., Wardana, L. W., Wibowo, A., & Narmaditya, B. S. (2021). Does entrepreneurship education and culture promote students' entrepreneurial intention? The mediating role of an entrepreneurial mindset. *Cogent Education*, 8(1), 1918849. doi:10.1080/2331186X.2021.1918849
- Nabi, G., Holden, R., & Walmsley, A. (2010). Entrepreneurial intentions among students: Towards a re-focused research agenda. *Journal of Small Business and Enterprise Development*, 17(4), 537-551. doi:10.1108/14626001011088714
- Ndou, V., Mele, G., & Vecchio, P. D. (2019). Entrepreneurship education in tourism: An investigation among European Universities. *Journal of Hospitality, Leisure, Sport & Tourism Education*, 25, 100175. doi:10.1016/j.jhlste.2018.10.003
- Neneh, B. (2020). Entrepreneurial passion and entrepreneurial intention: the role of social support and entrepreneurial self-efficacy. *Studies in Higher Education*, 47(1), 1-17. doi:10.1080/03075079.2020.1770716
- Nunnally, J. C. (1978). *Psychometric theory, 2nd Edition*. New York: McGraw-Hill.

- Obschonka, M., Moeller, J., & Goethner, M. (2019). Entrepreneurial Passion and Personality: The Case of Academic Entrepreneurship. *Frontiers in Psychology, 9*, 2697. doi:10.3389/fpsyg.2018.02697
- Pfeifer, S., Sarlija, N., & Zekic-Susac, M. (2016). Shaping the Entrepreneurial Mindset: Entrepreneurial Intentions of Business Students in Croatia. *Journal of Small Business Management, 54(1)*, 102-117. doi:10.1111/jsbm.12133
- Ribeiro-Soriano, D. (2017). Small business and entrepreneurship: their role in economic and social development. *Entrepreneurship & Regional Development, 29 (1-2)*, 1-3.
- Rodriguez, S., & Lieber, H. (2020). Relationship Between Entrepreneurship Education, Entrepreneurial Mindset, and Career Readiness in Secondary Students. *Journal of Experiential Education, 43(1)*, 277-298. doi:10.5382592091946
- Saptono, A., Wibowo, A., Narmaditya, B. S., Karyaningsih, R. D., & Yanto, H. (2020). Does entrepreneurial education matter for Indonesian students' entrepreneurial preparation: The mediating role of entrepreneurial mindset and knowledge. *Cogent Education, 7(1)*, 1836728. doi:10.1080/2331186X.2020.1836728
- Shane, S., & Venkataraman, S. (2000). The Promise of Entrepreneurship as a Field of Research. *Academy of Management Review, 25(1)*, 217-226. doi:10.5465/amr.2000.2791611
- Souitaris, V., Zerbini, S., & Al-Laham, A. (2007). Do entrepreneurship programs raise the entrepreneurial intention of science and engineering students? The effect of learning, inspiration, and resources. *Journal of Business Venturing, 22(4)*, 566-591. doi:10.1016/j.jbusvent.2006.05.002
- Thompson, E. R. (2009). Individual Entrepreneurial Intent: Construct Clarification and Development of an Internationally Reliable Metric. *Entrepreneurship Theory and Practice, 33(3)*, 669-694. doi:10.1111/j.1540-6520.2009.00321.x
- Udhayan, P. (2019). The Role of Self-Efficacy and Entrepreneurial Self-Efficacy on the Entrepreneurial Intentions of Graduate Students: A Study among Omani Graduates. *Entrepreneurial Business and Economics Review, 7(4)*, 7-20. doi:10.15678/EBER.2019.070401
- Vadlander, S. W., Sjølvell, I., & Klyver, K. (2020). Entrepreneurship as a vocational choice in contested entrepreneurship communities: The role

- of entrepreneurs' justification strategies. *Journal of Business Venturing*, *35*(3), 106006. doi:10.1016/j.jbusvent.2020.106006
- Vaughan, N. D. (2014). Student Engagement and Blended Learning: Making the Assessment Connection. *Education Sciences*, *4*(4), 247-264. doi:10.3390/educsci4040247
- Wardana, L. W., Narmaditya, B. S., Wibowo, A., Mahendra, A. M., Wibowo, N. A., Harwida, G., & Rohman, A. N. (2020). The impact of entrepreneurship education and students' entrepreneurial mindset: The mediating role of attitude and self-efficacy. *Heliyon*, *6*(9), e04922. doi:10.1016/j.heliyon.2020.e04922
- Wei, X., Liu, X., & Sha, J. (2019). How Does the Entrepreneurship Education Influence the Students' Innovation? Testing on the Multiple Mediation Model. *Frontiers in Psychology*, *10*, 1557. doi:10.3389/fpsyg.2019.01557
- Wu, L., Jiang, S., Wang, X., Yu, L., Wang, Y., & Pan, H. (2022). Entrepreneurship Education and Entrepreneurial Intentions of College Students: The Mediating Role of Entrepreneurial Self-Efficacy and the Moderating Role of Entrepreneurial Competition Experience. *Frontiers in Psychology*, *12*, 727826. doi:10.3389/fpsyg.2021.727826
- Wu, S., & Wu, L. (2008). The impact of higher education on entrepreneurial intentions of university students in China. *Journal of Small Business and Enterprise Development*, *15*(4), 752-774. doi:10.1108/14626000810917843
- Yuan, C.-H., Wang, D. J., Mao, C. Y., & Wu, F. X. (2020). An Empirical Comparison of Graduate Entrepreneurs and Graduate Employees Based on Graduate Entrepreneurship Education and Career Development. *Sustainability*, *12*(24), 10563. doi:10.3390/su122410563
- Zhao, H., Seibert, S. E., & Hills, G. E. (2005). (2005). The mediating role of self-efficacy in the development of entrepreneurial intentions. *Journal of Applied Psychology*, *90*(6), 1265-1272. doi:10.1037/0021-9010.90.6.1265